

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.ГАНХҮҮ
ТАНАА

2020 Ор. 29 № 06/1407
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Компанийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 15-аас 2020 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн Чанарын хяналтын менежер Х.Дорж, ахлах аудитор Т.Сугарсүрэн, аудиторын туслах Т.Энхжаргал, П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10/318 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Эрдэнэс Монгол” ХХК болон Азийн хөгжлийн банкны хооронд 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны зээлээр 35.0 сая ам доллар, “Эрдэнэс Монгол” ХХК-аас 6.2 сая ам долларыг тус тус санхүүжүүлэхээр тохирсон байна. Төслийн дуусгавар болох хугацаа 2019 оны 04 сарын 30-ний өдөр байсан ч Азийн хөгжлийн банкнаас гэрээний хугацааг 2021 оны 04 сарын 30 хүртэл сунгасан.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн эрхэм зорилго нь “Эрдэнэс Монгол” ХХК нь өөрийн болон охин, хараат компаниудын дунд ба урт хугацааны стратегийг хөгжүүлэх, ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх ба бүтээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтын чадамжийг нэмэгдүүлэх ба төрөлжүүлэх, нэгдсэн үйл ажиллагаа, тайлагналын системийг сайжруулах, менежментийн чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

- Компанийн стратегийг шинэчлэн боловсруулах
- Хөрөнгө оруулалтын чадавхыг бэхжүүлэх төрөлжүүлэх
- Удирдлагын нэгдсэн мэдээллийн систем (ERP) нэвтрүүлж ажиллах

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Infosystem Pacs программ хангамж ашигладаг байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн “үйл ажиллагааны зардал”-ын дүнг

сонгож, эрсдэлийн түвшинг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 1,426,397.9 мянган төгрөгөөс тооцон 14,264.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,904,679.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	256,667.1	2,161,346.6	1,904,679.4
Нийт хөрөнгө	256,667.1	2,161,346.6	1,904,679.4
Өр төлбөр	54,540.4	-	(54,540.4)
Хуримтлагдсан үр дүн	202,126.7	2,161,346.6	1,959,219.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	256,667.1	2,161,346.6	1,904,679.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь Азийн хөгжлийн банкнаас 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан менежментийн зөвлөхийн төлбөр юм. Менежментийн зөвлөх компанийн гэрээн дэх үйл ажиллагааны цар хүрээ, төлөвлөгөөг илүү нарийвчлах ажлуудаас болж хугацаа алдаж үндсэн хийгдэх ажлууд хоцорч эхэлсэнтэй холбогдон гэрээний төлбөр хойшлогдсон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь 2018 оны жилийн эцсээр 2018 оны 12-р сарын төслийн зөвлөхүүдийн цалингийн өглөг 54,540.4 мянган төгрөгийг барагдуулсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Нийт орлогын батлагдсан төсөв, гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
АХБ-ны санхүүжилт	22,214,010.4	3,172,267.4	19,041,743.0	14.3
“Эрдэнэс монгол” ХХК-ийн санхүүжилт	724,164.2	130,649.8	593,514.4	18.0
Нийт дүн	22,938,174.6	3,302,917.2	19,635,257.4	14.4

Тайлант онд “Эрдэнэс монгол” нэгдлийн хэмжээнд удирдлагын мэдээллийн систем буюу ERP системийг нэвтрүүлэхээр менежментийн зөвлөх, программ хангамжийг авахаар Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс 22,214,010.4 мянган төгрөг, “Эрдэнэс Монгол”

ХХК-иас 724,164.2 мянган төгрөг төсөвлөснөөс 2019 оны гүйцэтгэлээр Азийн хөгжлийн банкнаас 3,172,267.4 мянган төгрөг, “Эрдэнэс монгол” ХХК-иас 130,649.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 3. Төсвийн зарцуулалт

/мянган төгрөг/

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	16,787,754.6	1,481,530.5	15,306,234.1	9.0
Хөрөнгийн зардал	6,150,420.0	-	6,150,420.0	0.0
Нийт дүн	22,938,174.6	1,481,530.5	21,456,654.1	6.5

2019 онд 1,481,530.5 мянган төгрөгийн урсгал зардал гарснаас төсөл хэрэгжүүлэх нэгжийн болон зөвлөхүүдийн цалингийн зардалд 723,511.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын зардалд 82,015.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 623,726.7 мянган төгрөг, төслийн үйл ажиллагааны зардалд 52,227.6 мянган төгрөг зарцуулжээ.

Хөрөнгийн зардлын төлөвлөгөөнд “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд ERP системийн программ хангамж, техник хангамжтай холбоотой зардлыг төлөвлөсөн боловч уул уурхайн үйл ажиллагааны (MOS)-ийн модулийг нэмэлтээр оруулах шаардлагатай болсон тул ERP системийн техникийн шаардлага, ажлын цар хүрээг шинэчлэх, улмаар ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг дахин боловсруулах шаардлага үүссэн тул тус худалдан авалтыг 2020 оны төлөвлөгөөнд тусгахаар хойшлуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2019 оны ажлын төлөвлөгөөнд ERP системийн программ хангамж, техник хангамж нэвтрүүлэлтийн ажил төлөвлөгдсөн ба уг ажил нь техникийн шаардлага, ажлын цар хүрээг шинэчлэх, улмаар ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн тул 2019 онд багтаж гүйцэтгээгүй байгаа. Тиймээс дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь Шилэн дансанд мэдээлэл байршуулдаггүй ба “Эрдэнэс Монгол” ХХК байршуулдаг.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Энэ төсөлд өмнөх аудитын дүгнэлт тайлан байхгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах менежментийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	256,667,122.94	2,161,346,564.08
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	256,667,122.94	2,161,346,564.08
Урьдчилж төлсөн зардал	-	-
Урьдчилж төлсөн зардал	-	-
БАРАА МАТЕРИАЛ		
Бэлэн бүтээгдэхүүн	-	-
Хангамжийн материал	-	-
Түлш, шатах тослох материал	-	-
НӨӨЦИЙН БАРАА	-	-
БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,667,122.94	2,161,346,564.08
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	-
Биет хөрөнгө	-	-
Авто-тээврийн хэрэгсэл	-	-
Хуримтлагдсан элэгдэл Авто-тээврийн хэрэгсэл	-	-
Машин, тоног төхөөрөмж	-	-
Хуримтлагдсан элэгдэл Машин тоног төхөөрөмж	-	-
Тавилга, аж ахуйн эд хогшил	-	-
Хуримтлагдсан элэгдэл Тавилга эд хогшил	-	-
Биет бус хөрөнгө	-	-
Программ хангамж	-	-
Хуримтлагдсан элэгдэл Программ хангамж	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	256,667,122.94	2,161,346,564.08
Богино хугацаат өр төлбөр		
Ажиллагчидтай холбогдсон өглөг	54,540,397.36	-
Байгууллагад төлөх өглөг	-	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБРИЙН ДҮН	54,540,397.36	-
Урт хугацаат зээл	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	54,540,397.36	-
Засгийн газрын хувь оролцоо	-	-
Өмнөх үеийн үр дүн	634,372,566.31	202,126,725.58
Тайлант үеийн үр дүн	(432,245,840.73)	1,959,219,838.50
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	202,126,725.58	2,161,346,564.08
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН /ӨМЧИЙН ДҮН	256,667,122.94	2,161,346,564.08

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,328,065,197.88	3,312,733,298.14
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,328,065,197.88	3,312,733,298.14
Нийтлэг татварын бус орлого	2,328,065,197.88	3,312,733,298.14
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,328,065,197.88	3,312,733,298.14
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,849,782.12	9,683,035.46
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,127,807,467.92	3,172,400,435.08
“Эрдэнэс Монгол” ХХК санхүүжилт	196,407,947.84	130,649,827.60
Бусад орлого	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,757,795,444.55	1,426,397,868.06
УРСГАЛ ЗАРДАЛ	2,757,795,444.55	1,426,397,868.06
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	-
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,952,735,110.39	750,264,020.77
Үндсэн цалин	1,836,493,538.19	668,248,862.79
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,241,572.20	82,015,157.98
Тэтгэврийн даатгал	-	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,415,275.63	45,838,560.00
Байрны түрээс	64,415,275.63	45,838,560.00
Хангамж, бараа материалын зардал	15,751,100.01	2,477,381.83
Бичиг хэрэг	960,318.18	583,545.45
Тээвэр, шатахуун	-	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,500,118.18	1,326,600.00
Ном, хэвлэл	-	-
Аж ахуйн материал худалдан авах зардал	290,663.65	567,236.38
Эд хогшил, урсгал засварын зардал	-	318,727.79
Урсгал засвар	-	318,727.79
Томилолт, зочны зардал	17,229,139.16	3,588,000.00
Гадаад албан томилолт	12,788,780.16	3,588,000.00
Дотоод албан томилолт	4,440,359.00	-
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	707,664,819.36	623,911,177.67
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	623,726,700.02
Даатгалын үйлчилгээ	-	-
Зээлийн хүү, амлалтын зардал	701,028,552.12	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	636,267.24	184,477.65
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
Дотоод эх үүсвэрээр	-	-
Хаагдсан данс	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(429,730,246.67)	1,886,335,430.08
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	472.40	73,609,705.79
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	472.40	73,609,705.79
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,516,066.46	725,297.37
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,516,066.46	725,297.37
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(432,245,840.73)	1,959,219,838.50

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,429,921,351.09	3,181,950,416.80
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,429,921,351.09	3,181,950,416.80
Нийтлэг татварын бус орлого	1,429,921,351.09	3,181,950,416.80
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,429,921,351.09	3,181,950,416.80
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,849,009.43	9,683,035.46
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,426,072,341.66	3,172,267,381.34
“Эрдэнэс монгол” ХХК-ийн санхүүжилт	-	-
Бусад орлого	-	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,976,496,845.29	1,350,880,681.45
УРСГАЛ ЗАРДАЛ	1,976,496,845.29	1,350,880,681.45
Цалин	1,958,808,376.83	723,511,047.57
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,688,468.46	627,369,633.88
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
Байрны түрээс	-	-
Хангамж, бараа материалын зардал	-	-
Бичиг хэрэг	-	-
Тээвэр, шатахуун	-	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
Ном, хэвлэл	-	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
Томилолт, зочны зардал	17,263,422.30	3,591,570.28
Гадаад албан томилолт	12,812,602.28	3,591,570.28
Дотоод албан томилолт	4,450,820.02	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	425,046.16	623,778,063.60
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	623,726,700.02
Банкны шимтгэл	425,046.16	51,363.58
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(546,575,494.20)	1,831,069,735.35
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
Дотоод эх үүсвэрээр	-	-
Барилга байгууламж	-	-
Тоног төхөөрөмж	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	472.40	73,609,705.79
Бусад эх үүсвэр	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	472.40	73,609,705.79
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(546,575,021.80)	1,904,679,441.14
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	803,242,144.74	256,667,122.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	256,667,122.94	2,161,346,564.08

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	634,372,566.31	634,372,566.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(432,245,840.73)	(432,245,840.73)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	202,126,725.58	202,126,725.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	202,126,725.58	202,126,725.58
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,959,219,838.50	1,959,219,838.50
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,161,346,564.08	2,161,346,564.08

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,938,174,582.44	1,481,530,509.04	21,456,644,073.40	6.5
УРСГАЛ ЗАРДАЛ	16,787,754,582.44	1,481,530,509.04	15,306,224,073.40	8.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,986,261,555.40	805,526,205.55	2,180,735,349.85	27.0
Цалин	2,643,535,930.40	723,511,047.57	1,920,024,882.83	27.4
Эрүүл мэндийн даатгалын хураамж	342,725,625.00	82,015,157.98	260,710,467.02	23.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,578,540.00	52,226,239.90	84,352,300.10	38.2
Байрны түрээс	74,634,240.00	45,838,560.00	28,795,680.00	61.4
Тоног төхөөрөмж, бичиг хэрэг, хангамжийн зардал	18,457,800.00	2,796,109.62	15,661,690.38	15.1
Томилолт, зочны зардал	43,486,500.00	3,591,570.28	39,894,929.72	8.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	11,338,949,847.76	623,726,700.02	10,715,223,147.74	5.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,338,949,847.76	623,726,700.02	10,715,223,147.74	5.5
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,325,964,639.28	51,363.58	2,325,913,275.70	0.002
Магадалшгүй зардал	2,325,964,639.28	51,363.58	2,325,913,275.70	0.002
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,150,420,000.00	-	6,150,420,000.00	0.0
Тоног төхөөрөмж	6,150,420,000.00	-	6,150,420,000.00	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,214,010,417.44	3,172,400,435.08	19,041,609,982.36	14.3
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	22,214,010,417.44	3,172,400,435.08	19,041,609,982.36	14.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,938,174,582.44	3,312,600,244.40	19,625,574,338.04	14.4
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	22,214,010,417.44	3,172,267,381.34	19,041,743,036.10	14.3
Хүүгийн орлого	-	9,683,035.46	(9,683,035.46)	
"Эрдэнэс Монгол" ХХК санхүүжих	724,164,165.00	130,649,827.60	593,514,337.40	18.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	256,667,122.94	256,667,122.94		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,161,346,564.08	2,161,346,564.08		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
АЖИЛЛАГСДЫН ТОО	4	4		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	3	3		

ТЭМДЭГЛЭЛ

A series of 32 horizontal dotted lines providing space for writing.

